



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 11/16

Сүмбэр сум

「 Албан тушаалын тодорхойлолт батлах  
тухай

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 27.5.11, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 37 дугаар зүйлийн 37.1.13, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн сургалтын албаны менежерийн албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, сургалтын албаны арга зүйч, багш нарын албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйчийн албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, Нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, Цахим сургалтын агуулга, хөгжүүлэлт, сургалтын нөөц хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар, Тоног төхөөрөмж, цахим сүлжээ, мэдээллийн сан хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг зургаадугаар, Дотуур байрны багшийн албан тушаалын тодорхойлолтыг долоодугаар, Номын санчийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг наймдугаар, Мэргэжлийн боловсролын багш нарын албан тушаалын тодорхойлолтыг есдүгээр, Ерөнхий эрдмийн багш нарын албан тушаалын тодорхойлолтыг аравдугаар, Захиргаа аж ахуйн албаны менежерийн албан тушаалын тодорхойлолтыг арваннэгдүгээр, Дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арванхоёрдугаар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арвангуравдугаар, Ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг арвандөрөвдүгээр, Тооцооны нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг арвантавдугаар, Сургалтын байгууллагын эмчийн албан тушаалын тодорхойлолтыг арванзургаадугаар, Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг

арвандолоодугаар, Захирлын туслах, бичиг хэргийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арванаймдугаар, Архивын ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арванесдүгээр, Няравын албан тушаалын тодорхойлолтыг хорьдугаар, Тогоочийн албан тушаалын тодорхойлолтыг хориннэгдүгээр, Жолоочийн албан тушаалын тодорхойлолтыг хоринхоёрдугаар, Сантехникчийн албан тушаалын тодорхойлолтыг хоринхоёрдугаар, Цахилгаанчны албан тушаалын тодорхойлолтыг хорингуравдугаар, Мужааны албан тушаалын тодорхойлолтыг хориндөрөвдүгээр, Тогоочийн туслах ажилтны албан тушаалын тодорхойлолтыг хоринтавдугаар, Харуулын албан тушаалын тодорхойлолтыг хоринзургаадугаар, Дотуур байрны жижүүрийн албан тушаалын тодорхойлолтыг хориндолоодугаар, Үйлчлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг хориннаймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Уг тушаалыг албажуулсан өдрөөс эхлэн шинэчлэн баталсан албан тушаалын тодорхойлолтыг мөрдөж ажиллахыг нийт багш, ажилтнуудад даалгасугай.

3.Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсантай холбогдуулан багш, ажилтнуудад танилцуулахыг сургалтын албаны менежер Ц.Мягмарсүрэн, Захиргаа аж ахуйн албаны менежер П.Мөнхцоож нарт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод чанарын баталгаажилт, статистик мэдээ хариуцсан ахлах ажилтан Д.Өнөржаргалд даалгасугай.

ЗАХИРАЛ



Ш.ОТГОНЖАРГАЛ

ገጠናዎች ላይ የሚኖሩት ሕጻናት

١٠٠

[illegible][illegible]

